



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 24 өдөр

Дугаар

А/420

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалт Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2025 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.2.1 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулагдах эх барих, нөхөн үржихүйн тусламжийн чанарыг дээшлүүлэх зорилгоор сумдын эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч, багийн эмч нарыг ажлын байранд нь чадавхжуулах сургалт зохион байгуулах ажилд хөрөнгө гаргасугай.

2.Шаардагдах 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун) –т үүрэг болгож ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

8200011196

